ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: СНАГ-2023/39/НА-СТА-ТӨА**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер: Ц.Хосжаргал**
Утас:260949 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
**Ахлах аудитор: В.Эрдэнэцогт**
Утас:263533 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ашид баланс аудит ХХК-ийн захирал Л.Майцэцэг**
Утас: 99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com

Улаанбаатар хот

## Агуулга

1. Хараат бус аудиторын санал дүгнэлт ........ 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл . 4
3. Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 9
 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 9
 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 9
 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 11
 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл ........ 13
4. Аудитын тайлан ........ 15
 4.1 Ерөнхий зүйл ........ 15
 4.2 Материаллаг байдал ........ 15
 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 15
 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 16
 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 17
 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 18
5. Аудитын илрүүлэлт ........ 18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ........ 23

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ААНОАТ | Аж ахуй нэгжийн орлогын албан татвар |
| НА | Нийцлийн аудит |
| НББББӨ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| НББОУС | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албар татвэр |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| СНАГ | Санхүү-нийцлийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| УТҮГ | Улсын төсөвт үйлдвэрийн газар |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.03.24 № 07/652

танай ____________-ны № ____________-т

АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 299.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр байгаа бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14,15 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар баталсан журам, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 13 дугаар зүйлийн 13.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд чөлөөлөгдөх орлогын дүнг 156.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан, дотоодын зах зээлээс худалдан авсан 4 суудлын авто машины 47.7 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг хасаж тооцсон;
- Нэр бүхий 35 байгууллага, иргэдээс худалдан авсан 192.3 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн цахим и-баримтыг бүрдүүлээгүй;

**Асуудлыг онцолсон хэсэг**

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь тайлант онд улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх 3,428.8 сая төгрөгийн "C" зөвшөөрөл 34634, 27.0 сая төгрөгийн "D" зөвшөөрөл 3072, 3.5 сая төгрөгийн "F" зөвшөөрлийн 212 бичиг олгож, нийт тусгай зөвшөөрлөөс 3,459.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Засгийн газрын "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 2022 оны 362 дугаар тогтоолын 5-д "... хилийн үнээр худалдан борлуулах, байнгын ачаа тээврийн хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийг олгох эрхийг олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх арга хэмжээ авах" гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 07/5262 дугаар албан бичгээр тус төвд олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах үүрэг өгсөн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны А-1/1378 дугаар албан бичгийн дагуу 2,579.8 сая төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

**Аудитын гол асуудал**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 632 дугаар тогтоолоор Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 26,176.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 24,053.4 сая төгрөгөөр, 2,123.5 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар баталсан байна. Гүйцэтгэлээр 31,351.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, зардал 23,511.9 сая төгрөгт хүрч, 7,839.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллажээ.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2022 оны ажил гүйцэтгэх гэрээнд 9 зорилтын хүрээнд 232 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 84.8 хувьтай гэж үнэлсэн байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2023\0315 SNAG-86.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Балансын үзүүлэлт | 2021 оны 12 сарын 31 | 2022 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 9,880,402,417.43 | 13,835,989,075.01 |
| 1.1.2 | Дансны авлага | 18,816,200.00 | 6,718,949.60 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 30,827.27 | 409,140,439.56 |
| 1.1.4 | Бусад авлага | 80,918,349.59 | 134,142,547.75 |
| 1.1.6 | Бараа материал | 1,967,496,453.83 | 2,196,802,718.28 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал, тооцоо | 123,639,646.90 | 152,639,084.59 |
| | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **12,071,303,895.02** | **16,735,432,814.79** |
| **1.2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 32,377,765,701.89 | 31,624,461,589.76 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 6,613,904,121.72 | 6,689,381,329.83 |
| 1.2.7 | Хойшлогдсон татварын хөрөнгө | - | 184,291,285.15 |
| | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **38,991,669,823.61** | **38,498,134,204.74** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **51,062,973,718.63** | **55,233,567,019.53** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 234,600,150.15 | 199,048,460.25 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 39,663.54 | - |
| 2.1.1.3 | Татварын өр | 714,818,250.79 | 6,855,600.00 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 234,553,947.03 | 450,614,862.19 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 51,119,000.00 | 51,119,000.00 |
| | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **1,235,131,011.51** | **707,637,922.44** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 5,271,229,888.79 | 5,500,349,778.52 |
| 2.1.2.4 | Хойшлогдсон татварын өр | 112,481,786.43 | 112,481,786.43 |
| | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **5,383,711,675.22** | **5,612,831,564.95** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **6,618,842,686.73** | **6,320,469,487.39** |
| **2.3** | **Эздийн өмч** | | |
| 2.3.1 | Өмч: Төрийн | 241,840,000.00 | 241,840,000.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 3,159,212,904.41 | 3,159,212,904.41 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 20,286,497,030.04 | 20,494,083,418.75 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 20,756,581,097.45 | 25,017,961,208.98 |
| | **Эздийн өмчийн дүн** | **44,444,131,031.90** | **48,913,097,532.14** |
| 2.4 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **51,062,973,718.63** | **55,233,567,019.53** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*/төгрөгөөр/*

| Мөр | Үзүүлэлт | 2021 оны 12 сарын 31 | 2022 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого/цэвэр/ | 25,511,850,741.62 | 26,051,390,343.43 |
| 2 | Борлуулалтын өртөг | 19,099,921,680.21 | 21,683,656,033.06 |
| 3 | **Нийт ашиг/алдагдал/** | **6,411,929,061.41** | **4,367,734,310.37** |
| 4 | Түрээсийн орлого | 159,087,832.17 | 154,086,815.47 |
| 5 | Хүүгийн орлого | 31,591,446.10 | 246,629,383.95 |
| 6 | Зорчигч тээврийн орлого | 1,536,812,031.58 | 4,757,736,520.69 |
| 8 | Бусад орлого | 32,630,127.17 | 141,515,929.61 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 16,979,952.24 | 35,848,476.50 |
| 11 | Ерөнхий ба удирдлагын зардал | 826,386,722.72 | 947,429,228.32 |
| 12 | Бусад зардал | 26,304,864.13 | 47,727,346.46 |
| 13 | Гадаад валютын ханшны олз/гарз/ | 160,896,251.92 | (737,165,140.60) |
| 14 | Бусад ашиг/алдагдал | (63,782,353.94) | (60,115,788.49) |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал/** | **7,399,492,857.32** | **7,839,416,979.72** |
| 19 | Орлогын татварын зардал | 949,873,214.37 | 998,196,898.94 |
| 20 | **Татвар дараах ашиг/алдагдал/** | **6,449,619,642.95** | **6,841,220,080.78** |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагд-сан ашиг /алдагдал | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **241,840,000.00** | **2,329,176,065.75** | **20,189,683,837.30** | **14,525,963,734.76** | **37,286,663,637.81** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | (9,061,807.26) | - | **(9,061,807.26)** |
| **Залруулсан үлдэгдэл** | **241,840,000.00** | **2,329,176,065.75** | **20,180,622,030.04** | **14,525,963,734.76** | **37,277,601,830.55** |
| Тайлант үеийн ашиг, алдагдал | - | - | - | 6,449,619,642.95 | **6,449,619,642.95** |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | 105,875,000.00 | - | **105,875,000.00** |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | (219,002,280.26) | **(219,002,280.26)** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | 830,036,838.66 | - | - | **830,036,838.66** |
| **2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **241,840,000.00** | **3,159,212,904.41** | **20,286,497,030.04** | **20,756,581,097.45** | **44,444,131,031.90** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - | - |
| **Залруулсан үлдэгдэл** | **241,840,000.00** | **3,159,212,904.41** | **20,286,497,030.04** | **20,756,581,097.45** | **44,444,131,031.90** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | - | 6,841,220,080.78 | 6,841,220,080.78 |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | 207,586,388.71 | - | 207,586,388.71 |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | (2,579,839,969.25) | (2,579,839,969.25) |
| **2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **241,840,000.00** | **3,159,212,904.41** | **20,494,083,418.75** | **25,017,961,208.98** | **48,913,097,532.14** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | 2021 оны 12 сарын 31 | 2022 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | **32,051,117,963.56** | **33,765,580,741.34** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 29,850,336,457.72 | 33,693,467,777.50 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 2,200,781,505.84 | 72,112,963.84 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **22,592,474,020.58** | **25,074,574,426.85** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 11,768,379,826.60 | 13,079,436,018.35 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,594,191,969.72 | 1,700,861,630.60 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 272,189,309.00 | 214,025,460.40 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 1,428,463,431.51 | 1,726,144,442.31 |
| 1.2.5 | Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 340,335,178.59 | 592,894,806.50 |
| 1.2.6 | Хүүгийн төлбөрт төлсөн | - | 54,621,988.47 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 1,810,535,349.38 | 4,608,274,235.53 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 56,385,411.83 | 65,452,598.34 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зардал | 5,321,993,543.95 | 3,032,863,246.35 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **9,458,643,942.98** | **8,691,006,314.49** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | **45,741,446.10** | **246,629,383.95** |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 14,150,000.00 | - |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүгийн орлого | 31,591,446.10 | 246,629,383.95 |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **741,710,946.04** | **1,893,932,516.50** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 549,765,785.29 | 1,865,042,516.50 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 180,235,386.75 | 28,890,000.00 |
| 2.2.3 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 11,709,774.00 | - |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(695,969,499.94)** | **(1,647,303,132.55)** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **697,176,342.64** | **3,088,116,524.36** |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 477,491,282.64 | 508,276,524.36 |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 219,685,060.00 | 2,579,840,000.00 |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(697,176,342.64)** | **(3,088,116,524.36)** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **8,065,498,100.40** | **3,955,586,657.58** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,814,904,317.03 | 9,880,402,417.43 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 9,880,402,417.43 | 13,835,989,075.01 |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| | **Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт** | | | | | | |
| Үүнээс: | Техникийн хяналт оношилгоо | мян/төг | 13,826,962.7 | 13,530,665.9 | 13,074,904.1 | (455,761.8) | 97.0 |
| | Зорчигч тээвэр | мян/төг | 5,099,124.2 | 7,496,269.0 | 8,851,557.5 | 1,355,288.5 | 118.0 |
| | Бусад | мян/төг | 8,345,885.2 | 5,150,000.0 | 9,424,897.5 | 4,274,897.5 | 183.0 |
| **2** | **Нийт орлого** | мян/төг | **27,271,972.1** | **26,176,934.9** | **31,351,359.0** | **5,174,424.1** | **120.0** |
| **3** | **Нийт зардал** | мян/төг | **19,872,479.2** | **24,053,376.8** | **23,511,942.0** | **(541,434.8)** | **98.0** |
| 4 | Татварын өмнөх ашиг | мян/төг | 7,399,492.9 | 2,123,558.1 | 7,839,417.0 | 5,715,858.9 | 369.0 |
| 5 | Цэвэр ашиг/алдагдал | мян/төг | 6,449,619.6 | 1,911,202.3 | 6,841,220.1 | 4,930,017.8 | 358.0 |
| 6 | Орлогын татварт | мян/төг | 949,873.2 | 212,355.8 | 998,196.9 | 785,841.1 | 470.0 |
| 7 | Төсвийн төлбөрт | мян/төг | 6,859,456.2 | 7,124,413.1 | 7,674,403.2 | 549,990.1 | 108.0 |
| 8 | Нийт авлага | мян/төг | 99,765.3 | 138,798.8 | 762,569.1 | 623,770.3 | 549.0 |
| 9 | Нийт өглөг | мян/төг | 6,618,842.6 | 5,701,551.6 | 6,320,469.5 | 618,917.9 | 111.0 |
| 10 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | мян/төг | 0.73 | 0.92 | 0.78 | (0.1) | 84.0 |
| 11 | Ногдол ашгийн өглөг | мян/төг | 219,685.0 | 1,355,676.9 | 2,579,840.0 | 1,224,163.1 | 190.0 |
| 12 | Хөрөнгө оруулалт | мян/төг | 1,307,266.7 | 2,746,923.1 | 2,491,693.0 | (255,230.1) | 91.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, тээвэрлэлтийг мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх, авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох, авто тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн хяналт, тээврийн хэрэгслийн бүртгэлийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх, нийгмийн хэрэгцээг хангасан аюулгүй, ая тухтай үйлчилгээний нөхцөлийг бий болгох зорилго бүхий Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

Авто тээврийн тухай хууль, Засгийн газрын тогтоол болон компанийн дүрэмд заасны дагуу дараах чиглэлээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналт тавих;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох, шилжилт хөдөлгөөн бүртгэх, бүртгэлээс хасах, тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон улсын дугаар нөхөн олгох, авто тээрийн хэрэгслийн талаарх мэдээллийн сан, бүртгэлийн сүлжээ байгуулах, мэдээллээр хангах;
- Улс, хот хооронд орон нутгийн нийтийн зорчигч болон ачаа тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг улсын хэмжээнд зохицуулах, зохион байгуулах, үйлчилгээг нийтийн тээврийн зорчигч тээврийн ажил, үйлчилгээг эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх;
- Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч болон ачаа тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шуурхай зохицуулалтаар хангах;
- Авто тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэлэх олгох;
- Улс, олон улс хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх;
- Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиалгат ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;
- Улс, хот хооронд орон нутгийн ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг судлан хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргах, дүгнэлтийг авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, сумын засаг даргад хүргүүлэх гэж тодорхойлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 213 тогтоолоор Тээврийн хэрэгслийн оношилгоо, хяналт зохицуулалтын алба УТҮГ-ыг анх байгуулж, Засгийн газрын 2013 оны 336 дугаар тогтоолоор Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ыг өөрчлөн байгуулсан байна.

Төвийн захирлын 2022 оны А/217 дугаар тушаалаар Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирлын зөвлөлийг захирал, захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтсийн дарга, санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, судалгаа, хөгжил чанарын удирдлагын төвийн дарга, ачаа тээврийн хэлтсийн дарга нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, захирлын зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих журмыг баталсан байна.

ТӨБЗГ-ын 2022 оны 510 дугаар тогтоолыг үндэслэн тус төвийн захирлын 2022 оны А/45 дугаар тушаалаар Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталжээ. Үүнд: 1 алба, 8 хэлтэс, 4 тасаг, Улаанбаатар хот дахь Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв, техник хяналтын үзлэгийн 3 төв, зорчигч тээврийн 2 төв, аймгийн автотээврийн 21 төв, Замын-Үүд, Цогтцэций салбар гэж баталсан байна.

Үйлдвэрийн газрын хэмжээнд төвд 11, орон нутгийн салбарт 43 нийт 54 гэрээт ажилтан ажиллаж байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно" гэж заасан байна.

Энэ хүрээнд Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2021 оны А/199 дугаар тушаалаар баталсан "Авто тээврийн хэрэгсэлд техникийн үзлэг явуулах журам"-ын 2.3 дах шаардлагын дагуу чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 17020:2013 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Дорнод, Замын-Үүд, Сүхбаатар, Ховд, Төв, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь аймгуудын Автотээврийн төвүүдэд техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааг хамруулах, Хэмжил лаборатори ISO 17025, Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв ISO 17065 олон улсын стандартын шаардлагыг тус тус хангаан итгэмжлэгдэж, тохирлын үнэлгээний үйлчилгээг дараах гурван чиглэлээр явуулж байна. Үүнд:

- Авто тээврийн салбарт ашиглагдаж байгаа тоног, төхөөрөмжид шалгалт, тохируулга хийж, хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулах;
- Авто тээврийн хэрэгслээр хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд техник хяналт хийж, дүгнэлт гаргах;
- Авто тээврийн салбарт үйлчилгээ эхэлж байгаа нийтийн тээврийн байгууллагуудад болон авто засварын газруудад үйлчилгээний баталгаажуулалт хийх.

Дээрх чиглэлүүдээр тохирлын үнэлгээний үйлчилгээг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад үзүүлснээр авто тээврийн салбарын үйлчилгээний чанар дээшилж, үйлчлүүлэгчид зөв сонголт хийхэд туслахаас гадна худалдаа, тээврийг хөнгөвчлөн, авто тээврийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, чанар аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэх ач холбогдолтой арга хэмжээг авч ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- ЗГ-ын 2022 оны "Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээ" 388 дугаар тогтоол;
- ЗТХС-ын 2022 оны "Авто тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм өөрчлөлт оруулах тухай" А/113 дугаар тушаал;
- ЗТХС-ын 2022 оны "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам" А/112 дугаар тушаал;

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

ЗТХЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын тус яамтай байгуулсан "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэн биелүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон тус газрын үйл ажиллагаанд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж тайланг ЗТХЯ-ны 2022 оны 10а/3406 дугаар албан бичгийн хамт тус төвд хүргүүлсэн байна.

ЗТХС-ын 2016 оны 76 дугаар тушаалаар Авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээс 7 чиг үүргийг гэрээний үндсэн дээр Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-т шилжүүлэн гүйцэтгүүлж байна.

Энэ хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-тай "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г жил бүр байгуулж, гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулдаг ч 2022 оны гэрээ, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй байна.

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын Хяналт-шинжилгээ, дотоод аудитын албанаас тайлант онд харьяа хэлтэс, алба, салбаруудад 4 чиглэлийн хүрээнд 34 ажилд үнэлгээ, дотоод аудитын хяналт шалгалт хийхээр төлөвлөгөө баталж, гүйцэтгэлээр 29 ажлыг бүрэн хийж гүйцэтгэн тухай бүр шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, цаашид алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж, санал, дүгнэлт хүргүүлэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус үйлдвэрийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,170.6 сая төгрөгөөр буюу 8.2 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 9,880,402.4 | 13,835,989.1 | 3,955,586.7 |
| Авлага | 99,734.5 | 140,861.5 | 41,127.0 |
| Татвар, НДШ-ийн авлага | 30.8 | 409,140.4 | 409,109.6 |
| Бараа материал | 1,967,496.5 | 2,196,802.7 | 229,306.2 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 123,639.7 | 152,639.1 | 28,999.4 |
| Үндсэн хөрөнгө | 32,377,765.7 | 31,624,461.6 | (753,304.1) |
| Биет бус хөрөнгө | 6,613,904.1 | 6,689,381.3 | 75,477.2 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | - | 184,291.3 | 184,291.3 |
| **Нийт хөрөнгө** | **51,062,973.7** | **55,233,567.0** | **4,170,593.3** |
| Богино хугацаат өр төлбөр | 1,235,131.0 | 707,637.9 | (527,493.1) |
| Урт хугацаат өр төлбөр | 5,383,711.7 | 5,612,831.6 | 229,119.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 44,444,131.0 | 48,913,097.5 | 4,468,966.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **51,062,973.7** | **55,233,567.0** | **4,170,593.3** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 13,835.9 сая төгрөг болж, 3,955.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд бүртгэлийн үйлчилгээний үнэ, хөлсийг шинэчилснээр орлого нэмэгдэж, Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн хүрээнд зардлыг хэмнэж ажилласан нь нөлөөлжээ. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл төв болон 8 салбарын бэлэн мөнгө 10.4 сая, 28 салбарын 61 харилцах дансны 8,652.1 сая, төв салбарын хугацаатай хадгаламж 4 харилцах дансны 5,173.5 сая төгрөг байна.

Авлагын дансны эхний үлдэгдлээс Зорчигч тээврийн авлага 18.8 сая төгрөг барагдаж, тайлант онд GPS-ийн үйлчилгээний орлогын авлага 1,805.5 сая, байрны түрээсийн авлага 44.7 сая, гэрээт ажлын авлага 222.2 сая нийт 2,072.4 сая төгрөгөөр нэмэгджээ. Авлага дансны үлдэгдэлд өмнөх онуудад үүссэн 8.7 сая төгрөгийн авлага, 2 иргэн, 1 байгууллагатай холбоотой 36.2 сая төгрөгийн авлага барагдуулах үйл ажиллагааг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага дансны үлдэгдэл 409.1 сая төгрөг болсон нь тайлант хугацаанд татварын байгууллагад урьдчилж төлсөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 395.8 сая, нэмэгдсэн өртгийн албан татвар 13.3 сая төгрөгийн татварын авлага нөлөөлсөн байна.

Бараа материал худалдан авсан 2,769.7 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 409.9 сая төгрөг, тус төвийн захирлын 2022 оны А/313 тушаалаар акталсан цаашид ашиглагдах боломжгүй 159.4 сая төгрөгийн бараа материал, 3.6 сая төгрөгийн маягт, үнэт цаасны дүнгээр хасагджээ. Оны эцэст бараа материалын нөөц үүссэн 29 салбарын ашиглалтад байгаа хангамжийн материал 1,002.2 сая төгрөг буюу нийт бараа материалын үлдэгдлийн 45.6 хувийг, сэлбэг хэрэгсэл 453.3 сая төгрөг буюу 20.6 хувийг, үнэт цаас, маягт 564.7 сая төгрөг буюу 25.7 хувийг 176.5 сая төгрөг буюу 8.0 хувийг бичиг хэрэг, аж ахуйн материал тус тус эзэлж байна.

Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэл 152.6 сая төгрөг болж, 29.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацаанд 134.5 сая төгрөгийн гэрээт ажил, үйлчилгээний урьдчилгаа төлбөрөөр нэмэгдэж, 70.8 сая төгрөгийн хүлээн авсан шатахуунаар хасагдсан байна. Өмнөх оны 91.0 сая төгрөгийн хэрэгжиж дууссан зураг төслийн 4 ажлын урьдчилгаа төлбөр нь барилгын ажил эхлээгүй тул хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэгдээгүй байна.

Үндсэн хөрөнгө 2021 оны хөрөнгө оруулалтаар он дамжсан хэрэгжсэн 501.2 сая, 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 1,102.4 сая, худалдан авсан 27.7 сая, Говь-Алтай, Орхон, Ховд, Дархан, Замын-Үүд салбаруудын авто тээврийн төвүүдийн байрны их засварын капиталжуулалт 218.8 сая, Говьсүмбэр аймгийн ИТХ-ын даргын 2022 оны 21 дүгээр захирамжаар аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүжилтээр бэлтгэсэн 2.4 сая төгрөгийн төгрөгөөр тус тус нэмэгдэж, Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд ТӨБЗГ-ын 2022 оны 360, 449, 463 дугаар тогтоолуудаар нийт 90.7 сая төгрөгийн балансын үнэтэй 71.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 суудлын автомашиныг Засгийн газрын авто баазад, 1 суудлын машиныг

Цагдаагийн ерөнхий газарт балансаас балансат шилжүүлсэн, тайлант хугацааны 2,425.7 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө тайлант оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан тээврийн хэрэгслийн нэгдсэн программ хангамжийн хөгжүүлэлтийн капиталжуулалт 28.9 сая, эзэмшлийн газрыг бүртгэсэн Булган аймгийн 199.5 сая, Говь Алтай аймгийн 113.7 сая, Завхан аймгийн 8.5 сая, нийт автотээврийн төвүүдийн 321.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хойшлогдсон татварын хөрөнгө дансны үлдэгдэл 184.3 сая төгрөг болж бүртгэгдсэн тайлант хугацаанд валютын ханшны хэрэгжээгүй алдагдлын дүн нь санхүү, татварын зөрүүгийн тайлангийн түр зөрүүгээр үүссэн үлдэгдэл байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 707.6 сая төгрөг болж 527.5 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны НӨАТ болон ААНОАТ-ын үлдэгдэл өр төлбөр 714.8 сая төгрөгийг барагдуулсан нь нөлөөлсөн байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 336 дугаар тогтоолын 3 дахь заалтын дагуу 2001 онд Тээврийг хөгжүүлэх төслийн хүрээнд 3,940,000 SDR /зээлжих тусгай эрхтэй/ тэнцэх зээлийг хуучнаар Санхүү, эдийн засгийн яам болон Авто тээврийн газар хоорондын NDF-353 дугаар гэрээний дагуу Нордикийн хөгжлийн сангаар дамжуулан зээлдүүлэх 5,271.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийн үндсэн төлбөрт 508.3 сая төгрөг, тайлант хугацааны хүүгийн төлбөрт 46.5 сая төгрөгийг хуваарийн дагуу төлж 5,500.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хойшлогдсон татварын өглөг дансны үлдэгдэл 112.5 сая төгрөг тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

Эздийн өмчийн үлдэгдэл 48,913.1 сая төгрөг болж, 4,468.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 6,841.2 сая төгрөгийн ашигтай ажиллаж, ТӨБЗГ-ын 2022 оны "Ногдол ашиг төвлөрүүлэх тухай" А-1/1378 дугаар албан бичгийн дагуу 2,579.8 сая төгрөгийг Сангийн яамны Төрийн сангийн улсын төсвийн орлогын ногдол ашгийн дансанд төвлөрүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт СТОУС-ыг баримтлан мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран үйл явдал, ажил гүйлгээ хийгдсэн тухай тайлант хугацаанд хүлээн зөвшөөрч бүртгэх ба зардал, орлогын хоорондох шууд хамаарлыг үндэслэн орлого, үр дүнгийн тайланд зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэхээр тусгагдсан байна.
Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, бусад гэж ангилсан байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад 3,639.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын захирлын 2022 оны А/77 дугаар тушаалаар үйлдвэрийн газрын алба, хэлтэс, Улаанбаатар хот дахь төвүүд, орон нутаг дахь салбаруудын ажилчин, албан хаагчдын ажил, мэргэжлийн жагсаалт, үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоосон, А/321 дүгээр тушаалаар нэмэгдэл хөлс олгосон, ашиглалтын зардлын тариф нэмэгдсэн, Сангийн сайдын 2022 оны 122 дугаар тушаалаар албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлагдсанаар томилолтын зардал өссөн зэрэг шалтгаалжээ.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ 01

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 632 дугаар тогтоолоор Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 26,176.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 24,053.4 сая төгрөгөөр, 2,123.5 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,746.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 31,351.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 23,511.9 сая төгрөгийн зардал гарган, 7,839.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

**Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл:**

Нийт орлогын гүйцэтгэл 31,351.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 5,174.4 сая төгрөг буюу 20.0 хувиар давсан нь дэлхий нийтээр тархаад байсан /KOVID-19/ тахлын нөлөөлөл буурч хилийн боомтуудын үйл ажиллагаа сэргэж, олон улсын ачаа болон зорчигч тээвэрлэлт хэвийн үргэлжилж эхэлсэн нь голлон нөлөөлсөн байна.

**Техник хяналтын үзлэгийн орлого** 13,074.9 сая төгрөг бүрдүүлж, төлөвлөснөөс 455.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 598.6 мянган тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд хамруулж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.4 мянган тээврийн хэрэгсэл дутуу хамрагдсан үзүүлэлттэй байна. Энэ нь хувийн үзлэг оношилгооны газрууд олноор нээгдсэнтэй шууд холбоотой ба улсын хэмжээнд нийт 11 хувийн аж ахуйн нэгжийн үзлэг оношилгооны төв ажиллаж байна.

**Тээвэр зохицуулалтын орлогын бүрдүүлэлт** 8,851.6 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 1,355.3 сая төгрөгөөр өссөн нь хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, тээвэрлэлтийн болон хилийн хязгаарлалт цуцлагдаж 2022 оны 3 дугаар сараас хилийн боомтын үйл ажиллагаа эхэлснээр ОХУ-ын Хиагт, Улаан-Үүд, 5 дугаар сараас БНКазахстан улсын Нурсултан хот зэрэг улс хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагаа эхэлсэн нь орлого өсөхөд нөлөөсөн байна.

**Тээврийн хэрэгслийн бүртгэлийн орлого** 9,424.9 сая төгрөг бүрдүүлж, төлөвлөснөөс 4,284.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 97458 тээврийн хэрэгслийг шинээр, 528604 тээврийн хэрэгслэлийн шилжих хөдөлгөөн, 111588 улсын дугаар солилт, 16579 гэрчилгээний нөхөлт, гадаад харилцааны яамны 75 тээврийн хэрэгсэлд ДК дугаар, олон улсын тээвэр хийж байгаа 101 тээврийн хэрэгсэлд НАА серийн дугаар олголтыг тус тус бүртгэснээр бүртгэлийн орлого 83.0 хувиар давуулан биелүүлэхэд нөлөөлсөн байна.

ЗТХС-ын 2022 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг дуудлага худалдаагаар зохион байгуулах журам"- ийн дагуу тайлант онд 10 серийн 4576 дугаарыг 7,534.9 сая төгрөгөөр борлуулж, 273.5 сая төгрөгийг дуудлага худалдааны үйл ажиллагааны зардалд зарцуулж, буцаалт хийгдэх нийт 9300 иргэний 2,867.8 сая төгрөгийн дэнчинг буцаан олгосон бөгөөд улсын дугаарын дуудлага худалдаанаас төвлөрсөн 4,390.1 сая төгрөгийг "Хүүхдийн төлөө" тусгай санд шилжүүлжээ.

**Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл:**

Нийт зардлын гүйцэтгэл 23,511.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 541.4 сая төгрөг буюу 2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хууль, ТӨБЗГ-ын 2022 оны А-1/997 дугаар чиглэл хүргүүлэх тухай албан бичиг, ЗТХС-ын А/93 дугаар тушаалаар өгөгдсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэн хэмнэлтийн горимд шилжиж, хэмнэлтийн төлөвлөгөө боловсруулан биелэлтийг ханган ажилласантай холбоотой байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 20 төсөл, арга хэмжээнд 2,746.9 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 2,467.7 сая төгрөг зарцуулжээ.

Тайлант онд цэвэр ашиг 6,841.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 4,930.0 сая төгрөгөөр илүү байгаа нь техник хяналт үзлэгийн, бүртгэлийн, хөдөлгөөн хяналт удирдлагын орлогын өсөлт болон зардлын бодит хэмнэлт нөлөөсөн байна.

ТӨБЗГ-ын 2022 оны "Ногдол ашиг төвлөрүүлэх тухай" А-1/1378 дугаар бичгийн дагуу тайланд онд 2,579.8 сая төгрөгийн ногдол ашгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Мөн ТӨБЗГ-т түрээсийн орлогын 40.0 хувь болох 68.9 сая, улсын төсөвт улсын тэмдэгтийн хураамжийн 1,681.8 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.2-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Автотээврийн үндэсний төв ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах талаар тендерийн материалыг хуулийн дагуу бүрдүүлж архивлах, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэж тайлагнах, хянах үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгах, санхүүгийн ажилтнуудын ажил, үүрэг хариуцлагыг ажлын байрны тодорхойлолтод дэлгэрэнгүй оруулж өгөх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ашид баланс аудит ХХК-ийн захирал Л.Майцэцэг, ахлах аудитор Д.Гандолгор, аудитор Д.Алтанцэцэг, туслах аудитор Д.Сэрчинмаа нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Л.Оюунчимэг хэрэгжүүлсэн.

Автотээврийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 1/200 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох суурь үзүүлэлтийг орлогын дэлгэрэнгүй тайлангийнр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн нийт зардал 19,969.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 299.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын захирлын 2022 оны Б/255, Б/256, Б/257 дугаар тушаалаар нэр бүхий 3 дэд захирлын хөдөлмөрийн гэрээг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөр дуусгавар болгосон шийдвэр гарсан байна.

ТӨБЗГ-ын 2022 оны Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай 449, 463, 360 дугаар тогтоолуудын дагуу тус үйлдвэрийн газрын 2 суудлын автомашиныг "Засгийн газрын авто бааз" УТҮГ-т, 1 суудлын автомашиныг Цагдаагийн Ерөнхий газарт шилжүүлэх арга хэмжээ авсан байна.

Энэ хуулийн хүрээнд дэд дарга, орлогчийн орон тоог хассанаар 58.4 сая төгрөгийн цалинтай холбоотой зардал, албан тушаалын автомашинтай холбоотой 66.7 сая төгрөгийн цалингийн зардал, сэлбэг, шатахууны зардал 125.1 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Автотээврийн үндэсний төв нь тайлант онд нийт 61,851.9 сая төгрөгийн 1953 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5 мэдээллийг байршуулаагүй, 2,156.8 сая төгрөгийн 88 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ"* гэж заасантай тус тус нийцэхгүй, зохистой бөгөөд нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмж өгөв.

Харьяа салбаруудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 809.7 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 809.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Автотээврийн үндэсний төв нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын татварын тодорхойлолтод өрийн үлдэгдэлтэй, санхүүгийн чадавхын шалгуурыг хангаагүй, үнэлгээний хорооны даргын шийдвэргүй нэр бүхий 4 байгууллагатай гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 "*Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй*", 15 дугаар зүйлийн 15.1 "*Захиалагч тендерт оролцогчоос гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхтайгаа батлсан нотолгоо ирүүлэхийг шаардаж болно*", 15.2 "*Захиалагч санхүүгийн чадавхын шаардлагыг тендерийн, эсхүл урьдчилсан сонголтын баримт бичигт тусгана*" гэж тус тус заасантай нийцэхгүй, зохистой бөгөөд нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Хуулийг хэрэгжүүлж ажиллагаагүй буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Бараа, ажил үйлчилгээ худалдан авах тендерийн баримт бичигт "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл", Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, дүгнэлтэд зарим гишүүд гарын үсэг зураагүй, тендер шалгаруулалтын хавтаст хэрэгт гэрээ дүгнэсэн актыг хавсаргаагүй зэрэг зөрчил нийтлэг гарч байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дугаар зүйлийн 47.-д ".Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах...", Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар батлагдсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын 2.19-д ..."Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийн загварын дагуу тухайн худалдан авах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар батлагдсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"- мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Зохистой бөгөөд нийцсэн байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж, заавар, журамтай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар НӨАТ-ыг хувь тэнцүүлж хасаагүй 25.5 сая, олон улсын гишүүнчлэлийн төлбөрийг шилжүүлэхдээ НӨАТ, ААНОАТ ногдуулж тайлагнаагүй 1.6 сая, нэр бүхий 6 ажилтанд цалин, хөлс, нэмэгдэл илүү тооцож олгосон 3.2 сая нийт 30.3 сая төгрөгийн алдаа илэрснээс цалин, хөлстэй холбоотой 1.9 сая төгрөгийн алдааг залруулсан байна.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1 төлбөрийн акт тогтоож, хүргүүлсэн 7 албан шаардлага, өгсөн 23 зөвлөмж өгснийг 89.0 хувьтай байна.

*Хүснэгт 2. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар өгсөн | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 19,551.2 | 1 | 19,551.2 | 100.0 |
| Албан шаардлага | 7 | 56,185.6 | 5 | 56,185.6 | 71.4 |
| Зөвлөмж | 23 | 165,350.7 | 22 | 74,336.3 | 95.6 |
| **Нийт дүн** | **31** | **241,087.5** | **30** | **150,073.1** | **89.0** |

Төвийн харьяа 28 салбарын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах тухай УАГ-ын 2022 оны 455/АО160067 дугаар сахилгын хариуцлагыг оногдуулсан боловч, зөрчлийг давтан гаргасан байна.

Драгон холдинг ХХК-тай байгуулсан 2016 оны ХХАГ16/020 дугаар гэрээний дагуу хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна. Уг хөрөнгийг Драгон холдинг ХХК-ны улсын бүртгэлийн гэрчилгээнээс хасаж, төрийн өмчид бүртгэж өгөх тухай 2022 оны 1/1444 дугаар хүсэлтийг ТӨБЗГ-т хүргүүлсэн боловч албан ёсны хариу ирээгүй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд өмнөх он болон тайлант хугацаанд хэрэгжиж дууссан зураг төслийн 4 ажлын нийт 91.0 сая төгрөг бүртгэлтэй байна. Зураг төслийн ажил хийгдэж дууссан боловч барилгын ажил эхлээгүй байгаа тул урьдчилж төлсөн зардлыг ТӨБЗГ-т асуудлыг шийдэх талаар хүсэлт явуулаагүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хэнтий, Сүхбаатар аймгийн автотээврийн төвүүд нь тэмдэгтийн хураамжийн орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, тайлагнаж байгаа эсэхийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын нийт 493.8 сая төгрөгийн алдаа[1], үүнээс харьяа салбаруудын 10.1 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулав.

<u>*Залруулсан алдаа:*</u>

Санхүүгийн тайланд дараах алдаануудыг залруулав. Үүнд:

- Үнэ төлбөргүй шилжиж ирсэн 85.8 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн;
- Гадаад валютын 737.2 сая төгрөгийн бодит бус алдагдалд ногдох 184.3 сая төгрөгийн татварыг хойшлогдсон татварын хөрөнгөөр бүртгээгүй.

[1]Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- ААНОАТ-ын ногдуулалтыг 203.6 сая төгрөгөөр, НӨАТ-ын ногдуулалтыг 9.0 сая дутуу тооцсон;
- Нэр бүхий 12 иргэнд 6 тээврийн хэрэгслийн дулаан зогсоолын 11.2 сая төгрөгийн төлбөрийг шилжүүлэхдээ ХХОАТ-ыг суутгасан боловч тайлагнаагүй;
- Харьяа 3 аймаг, 1 салбарын санхүүгийн байдлын тайлан болон тодруулга дахь мөнгөн дүнгүүд уялдаагүй 7.9 сая төгрөгөөр, бараа материал, авлага, өглөгийн дансдууд 2.2 сая төгрөгийн зөрүүтэй.

Аудитаар нийт 1,191.7 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 13.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 571.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 606.5 сая төгрөгийн зөрчилд 30 зөвлөмж өгч, хариуцлага тооцох 2 албан шаардлага хүргүүллээ. Аудитаар илэрсэн 1,191.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 299.5 сая төгрөгөөс давсан тул тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Тайлант онд нэр бүхий ажилтанд өвчтэй, чөлөөтэй үед ажилласнаар ажлын цагийг бүртгэж, 1.3 сая төгрөгийн цалин бодож олгосон, Удирдах ажилтны зөвлөгөөнд зориулж 10.0 сая төгрөг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "*нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчим*", 18 дугаар зүйлийн 18.1 "*нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*", 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба* төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 "*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана*", 15.2.3 "*сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх*", Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын 5.1 "*бүх төрлийн сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах*" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Төлбөрийн акт тогтоох

### 5.2 Албан шаардлага

1. Төвийн захирлын тушаалаар нэр бүхий 3 дэд захирлын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөр дуусгавар болгож, 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор ажил хүлээлцэх тухай шийдвэр гарсан боловч 6 дугаар сард 14 хоног ажиллаж, 5,071.5 сая төгрөгийн цалинг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах*" Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3 "*Ажил олгогч ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон тухай шийдвэртээ ажил хүлээлгэн өгөх хугацааг заана*", 83.5 "*Ажил олгогч ажилтанд энэ хуулийн 83.3-т заасан хугацааны цалин хөлсийг тооцож олгоно*" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Захирлын тушаалыг мөрдөж ажиллагаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Ахмадууд хүлээн авах арга хэмжээ болон удирдах ажилтны хурал, зөвлөгөөн зохион байгуулж 40.9 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2 "*Төсвийн*

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана*", 15.2.3 "*сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх*", Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын 5.1 "*бүх төрлийн сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах*" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллагаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Нэр бүхий 35 байгууллага, иргэдээс худалдаж авсан 192.3 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн цахим и-баримтыг бүрдүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 " *Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*" гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллагаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. CITA олон улсын гишүүнчлэлийн төлбөрийг шилжүүлэхдээ 1.6 сая төгрөгийн НӨАТ, ААНОАТ-ыг ногдуулж, төсөвт төлөөгүй нь Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6.8 "*.....Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн энэ хуулийн 4.1.6, 4.1.7, 8.3-т заасан орлого*", 20.2.4 "*энэ хуулийн 18.6.6, 18.6.8-д заасан орлогод 20 хувиар*", НӨАТ-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 "*оршин суугч бус этгээдээс энэ хуулийн 7.2.5-д гаалийн бүрдүүлэлт хийлгээгүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа үнийн дүнгээс албан татварыг суутган авч төсөвт төлнө*" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5. Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд чөлөөлөгдөх орлогын дүнг 156.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан, дотоодын зах зээлээс худалдан авсан 4 суудлын авто машины 47.7 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг хасаж тооцсон, нэр бүхий 4 байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлсөн 77.3 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг хуульд заасны дагуу хувь тэнцүүлж хасалт хийгээгүй нийт 282.0 сая төгрөгийн зөрчил нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "*Дараах үйлчилгээг албан татвараас чөлөөлнө*", 13.5.13 "*Авто тээврийн тухай хуулийн 3.1.11-д заасан нийтийн тээврийн үйлчилгээ*", 14 дүгээр зүйлийн 14.1.4.а "*барилга, байгууламж 10 жилээр*", *14.1.5.б "тоног төхөөрөмж 5 жилээр" тус тус хувь тэнцүүлэн хасагдуулна*", 14.6.1 "*суудлын машин, түүний эд анги, сэлбэг*" *албан татварын дүнгээс хасахгүй*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах*" гэж тус тус заасантай нийцэхгүй байна гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг мөрдөж ажиллагаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

6. Төвийн харьяа 28 салбарын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах тухай ҮАГ-ын 2022 оны 455/АО160067 дугаар сахилгын хариуцлагыг оногдуулсан боловч, зөрчлийг давтан гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11.*"нэгтгэсэн санхүүгийн тайлан" гэж Компанийн тухай хуулийн 6.4-т заасан санхүүгийн тайланг"*, 4.1 *"Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө"*, Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 *" Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ"*, 6.2 *" Хараат компани бие даасан тайлан баланс гаргадаг хуулийн этгээд байна"* гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

7. Татварын e-tax программын тооцооллоор суутган татварын 22.0 сая төгрөг, НӨАТ-ын өглөг 1.3 сая төгрөг, ААНОАТ-ын 6.2 сая төгрөгийн тус тус авлагатай, тэмдэгтийн хураамжийн тайлан 21.1 сая төгрөгийн өглөгтэй байхад тус төвийн тайланд тусгаагүй, татварын тооцооллыг эцэслээгүй санхүүгийн тайлан гаргасан нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19.*"суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг"*, 25 дугаар зүйлийн 25.6 *"Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ"* гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Тайлагналтай холбоотой асуудал**

*1.1 Илрүүлэлт:*

Нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахад салбар, нэгжүүдийн тайланг хүлээн авах, нэгтгэх, хянах, тайлагнах үйл ажиллагаа болон санхүүгийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлтод ажил үүрэг, хариуцлагын талаар оруулж тусгаагүй байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 "Хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцөлийг тусгана" 49.1.1 "ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг", Хөдөлмөрийн дотоод журмын 3.11 "ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:*

Санхүүгийн тайлан гаргах, хүлээн авах, нэгтгэх, хянах санхүүгийн ажилтнуудын ажил үүрэг, хариуцлагын талаар ажлын байрны тодорхойлтод дэлгэрэнгүй заалт оруулж биелэлтийг дүгнэж байх.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*2.1 Илрүүлэлт:*

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тэмдэгтийн хураамжийн орлогыг бүртгэх, улсын төсөвт төвлөрүүлэх, салбаруудын тэмдэгтийн хураамжийн тайлан нэгтгэх, хяналт тавих талаар тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:*

Байгууллагын гол орлого болох тэмдэгтийн хураамжийн орлогыг бүртгэлийн орлогоос салгаж харилцахын нэг дансанд бүртгэж, төсөвт төвлөрүүлэх, салбаруудын тэмдэгтийн хураамжийн тайланг нэгтгэж бүртгэх, тайлагнах, хяналт тавих талаар НББББ-т тодорхой тусгаж, хэрэгжүүлж ажиллах

**Татварын хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

*3.1 Илрүүлэлт:*

Төв болон салбарууд харьяа татварын байгууллагуудтай тооцоо хийж татварын үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д "Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа татварын албанд тушаана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*3.2 Өгсөн зөвлөмж:*

Татварын авлага, өглөгийн тооцоог хийж татварын үлдэгдлийг тухай бүр баталгаажуулж байх

Харьяа салбаруудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 668.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 10.1 сая төгрөгийн алдааг залруулж, 2.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 49.9 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 606.5 сая төгрөгийн зөрчилд 26 зөвлөмж өгсөн.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгаагүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үнэ төлбөргүй шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн байна. | 1 | 85,777.7 | | | 1 | 85,777.7 | 1 | 85,777.7 | | | | |
| Гадаад валютын бодит бус алдагдлыг тайлант хугацааны хасагдах зардлаар бүртгэж, ногдох татварыг хойшлуулж бүртгээгүй байна. | 1 | 184,291.3 | | | 1 | 184,291.3 | 1 | 184,291.3 | | | | |
| ААНОАТ-ын ногдуулалтыг 203,578.5 мянган төгрөгөөр, НӨАТ-ын ногдуулалтыг 8,988.7 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан байна. | 1 | 212,567.2 | | | 1 | 212,567.2 | 1 | 212,567.2 | | | | |
| Нэр бүхий 12 иргэнд 6 тээврийн хэрэгслийн дулаан зогсоолын төлбөр 11,168.1 мянган төгрөгийн шилжүүлэхдээ ХХОАТ-ыг суутган тооцсон боловч татварын тайлагнаагүй байна. | 1 | 1,016.0 | | | 1 | 1,016.0 | 1 | 1,016.0 | | | | |
| **Дүн** | **4** | **483,652.2** | - | - | **4** | **483,652.2** | **4** | **483,652.2** | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд нэр бүхий ажилтанд өвчтэй, чөлөөтэй үед ажилласнаар цагийг бүртгэж, 1,266.1 мянган | 1 | 11,266.1 | 1 | 11,266.1 | - | - | - | - | - | - | - | - |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛ
01 ХЯЗГААРЛАГДМАЛ
САНАЛ ДҮГНЭЛ

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| төгрөгийн цалин бодож олгосон, удирдах ажилтны зөвлөгөөнд зориулж 10,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | | | | | | | | | | | | |
| Төвийн захирлын тушаалаар нэр бүхий 3 дэд захирлын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөр дуусгавар болгож, 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор ажил хүлээлцэх тухай шийдвэр гарсан боловч 6 дугаар сард 14 хоног ажиллаж, 5,071.5 мянган төгрөгийн цалинг олгосон байна. | 1 | 5,071.5 | - | - | 1 | 5,071.5 | - | - | - | - | - | - |
| Ахмадууд хүлээн авах арга хэмжээ болон удирдах ажилтны хурал, зөвлөгөөн зохион байгуулж 40,984 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 40,984.0 | - | - | 1 | 40,984.0 | - | - | - | - | - | - |
| Нэр бүхий 35 байгууллага, иргэдээс худалдаж авсан 192,286.3 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн цахим и баримтыг бүрдүүлээгүй байна. | 1 | 192,286.8 | - | - | 1 | 192,286.8 | - | - | - | - | - | - |
| CITA олон улсын гишүүнчлэлийн төлбөрийг шилжүүлэхдээ 1,601.6 мянган төгрөгийн НӨАТ, ААНОАТ-ыг ногдуулж, төсөвт төлөөгүй | 1 | 1,601.6 | - | - | 1 | 1,601.6 | - | - | - | - | - | - |
| Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд чөлөөлөгдөх орлогын дүнг 156,952.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, Дотоодын зах зээлээс худалдан авсан 4 ширхэг суудлын авто машины 47,752.2 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг хасаж тооцсон, Нэр бүхий 4 байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлсөн 77,276.1 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг хуульд заасны дагуу хувь тэнцүүлж хасалт хийгээгүй нийт 281,981.2 мянган төгрөг байна. | 1 | 281,981.2 | - | - | 1 | 281,981.2 | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахад салбар, нэгжүүдийн тайланг хүлээн авах, нэгтгэх, хянах, тайлагнах үйл ажиллагаа болон санхүүгийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлтод ажил үүрэг, хариуцлагын талаар оруулж тусгаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Тэмдэгтийн хураамжийн, орлогыг бүртгэх, улсын төсөвт төвлөрүүлэх, салбаруудын тэмдэгтийн хураамжийн тайлан нэгтгэх, хяналт тавих талаар тусгаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Төв болон салбарууд харьяа татварын байгууллагуудтай тооцоо хийж татварын үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Төвийн харьяа 28 салбарын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах тухай УАГ-ын 2022 оны 455/АО160067 дугаар сахилгын хариуцлагыг оногдуулсан боловч, зөрчлийг давтан гаргасан байна. | 1 | - | - | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| Татварын etax программын тооцооллоор Суутган татвар 22,000.0 мянган төгрөг, НӨАТ-ын алданги 1,297.4 мянган төгрөг, ААНОАТ 6,169.4 мянган төгрөгийн тус тус авлагатай, тэмдэгтийн хураамжийн тайлан 21,092.1 мянган төгрөгийн өглөгтэй байхад тус төвийн тайланд тусгаагүй, татварын тооцооллыг эцэслээгүй санхүүгийн тайлан гаргасан байна. | 1 | - | - | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | 11 | 533,191.2 | 1 | 11,266.1 | 5 | 521,925.1 | 3 | - | 2 | - | - | - |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛ
01 ХЯЗГААРЛАГДМАЛ САНАЛ ДҮГНЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил* | | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 61,851,856.2 мянган төгрөгийн 1953 мэдээллийг ил тод байршуулахаас 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 205,058.7 мянган төгрөгийн 5 зарлагын гүйлгээг байршуулаагүй, 2,156,803.7 мянган төгрөгийн 88 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | 1 | - | | | | | 1 | - | | |
| *Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил* | | | | | | | | | | |
| Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын татварын тодорхойлолтод өрийн үлдэгдэлтэй, санхүүгийн чадавхын шалгуурыг хангаагүй, үнэлгээний хорооны даргын шийдвэргүй нэр бүхий 4 байгууллагатай гэрээ байгуулсан байна. | 1 | - | - | - | - | - | - | - | 1 | - |
| Бараа, ажил үйлчилгээ худалдан авах тендерийн баримт бичигт "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл", Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, дүгнэлтэд зарим гишүүд гарын үсэг зураагүй, тендер шалгаруулалтын хавтаст хэрэгт гэрээ дүгнэсэн актыг хавсаргаагүй зэрэг зөрчил нийтлэг гарч байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | 2 | - | - | - | - | - | 2 | - | 1 | - |
| **Нийт дүн** | 3 | - | | | | | 2 | - | 1 | - |

**Харьяа салбаруудын санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Салбарууд | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгаагүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| СХД-ийн зорчигч тээврийн төв | Авлагын үлдэгдлийг тодруулга тайланд 211.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 211.0 | - | - | 1 | 211.0 | 1 | 211.0 | - | - | - | - |
| | Борлуулалтын орлогыг тодруулга тайланд 7,772.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна. | 1 | 7,772.6 | - | - | 1 | 7,772.6 | 1 | 7,772.6 | - | - | - | - |
| Автотээврийн төвийн Замын-Үүд салбар | Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдол үүсгэх, бүртгэх тайлагнахад тооцооллын алдаатай бүртгэсэн байна. | 1 | 247.7 | - | - | 1 | 247.7 | 1 | 247.7 | - | - | - | - |
| | Нийгмийн даатгалын байгууллагын авлага 1.3 сая төгрөгийн авлагыг борлуулалтаар бүртгэсэн байна. | 1 | 1,286.3 | - | - | 1 | 1,286.3 | 1 | 1,286.3 | - | - | - | - |
| Өвөрхангай аймаг дахь Автотээврийн төв | Худалдан авсан 417.0 мянган төгрөгийн цэвэрлэгээний материалыг шууд зардлаар бүртгэсэн байна. | 1 | 417.0 | - | - | 1 | 417.0 | 1 | 417.0 | - | - | - | - |
| Говьсүмбэр аймаг дахь Автотээврийн төв | Ерөнхий журнал болон тодруулга тайланд зарцуулсан бараа материалыг худалдан авснаар тайлагнасан байна. | 1 | 206.8 | - | - | 1 | 206.8 | 1 | 206.8 | - | - | - | - |
| **Дүн** | | **6** | **10,141.4** | - | - | **6** | **10,141.4** | **6** | **10,141.4** | - | - | - | - |



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛ ХЯЗГААРЛАГДМАЛ САНАЛ ДҮГНЭ

**Харьяа салбаруудын санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Салбарууд | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нийслэлийн БЗД-ийн зорчигч тээврийн төв | Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 574.1 | - | - | - | - | 1 | 574.1 | - | - | - | - |
| Нийслэлийн БЗД-ийн зорчигч тээврийн төв | Хөрөнгийн ангиллыг буруу бүртгэсэн байна. | 1 | 4,881.7 | - | - | - | - | 1 | 4,881.7 | - | - | - | - |
| Нийслэлийн БЗД-ийн зорчигч тээврийн төв | Шатахууны нэгжийн үнэ, тоо хэмжээг буруу бүртгэсэн байна. | 1 | 1,025.5 | - | - | - | - | 1 | 1,025.5 | - | - | - | - |
| СХД-ийн зорчигч тээврийн төв | 2,856.0 мянган төгрөгийн ажил гүйлгээ нь анхан шатны баримтгүй байна. | 1 | 2,856.0 | - | - | - | - | 1 | 2,856.0 | - | - | - | - |
| СХД-ийн зорчигч тээврийн төв | Тайлант онд 2,500.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 2,500.0 | - | - | - | - | 1 | 2,500.0 | - | - | - | - |
| Автотээврийн үндэсний төвийн Замын-Үүд салбар | Кассаас бэлнээр худалдан авсан бараа материалын баримт шаардлага хангахгүй зарцуулалт тодорхой бус байна. | 1 | 660.0 | 1 | 660.0 | - | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Автотээврийн үндэсний төвийн Замын-Үүд салбар | Харилцах данснаас кассад 20.7 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн боловч кассад бүртгээгүй харилцах данснаас шууд 20.7 сая төгрөгөөр зарцуулснаар тайлагнасан байна. | 1 | 41,451.6 | - | - | 1 | 41,451.6 | - | - | - | - | - | - |
| Автотээврийн үндэсний төвийн Замын-Үүд салбар | Говийн бүс-2022 туршлага солилцох уулзалт, сургалтыг 12 дугаар сард Замын-Үүд суманд зохион байгуулж, хоол, өргөмжлөл, шагнал тэмцээн, спорт заал түрээслэх зардалд нийт 5,600.0 мянган төгрөг зарцуулсан байна. | 1 | 5,600.0 | - | - | 1 | 5,600.0 | - | - | - | - | - | - |
| Автотээврийн үндэсний төвийн Замын-Үүд салбар | Тээврийн хэрэгслийн техникийн үзлэгийн орлогыг үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээнд үндэслэн тооцоход орлогыг илүү бүртгэсэн байна. | 1 | 1,617.2 | - | - | - | - | 1 | 1,617.2 | - | - | - | - |
| Архангай аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 35 нэр төрлийн 51,008.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна. | 1 | 51,008.4 | | | | | 1 | 51,008.4 | | | | |
| Булган аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Түүвэрт хамрагдсан бараа материалын тайланд аудит хийхэд ажил гүйлгээг бараа материалын дансанд бүртгэлгүй шууд зардалд бичсэн зөрчил илэрсэн | 1 | 2,014.6 | - | - | 1 | 2,014.6 | - | - | - | - | - | - |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГ
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Булган аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Эрдэстранс ХХК, АТҮТ-өөс авсан бараа материал, үндсэн хөрөнгө, санхүүжилтийг тооцоо нийлж авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажаагүй байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| Булган аймаг дахь Автотээврийн үндэсний төв | ТӨБЗГ-ын 2019 оны 271-р тогтоолын 7-д заасны дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 43,438.9 мянган төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн бүртгэлд тусгаагүй, элэгдлийн зардлыг тооцохдоо ашиглалтын жил, тооцооллыг буруу тооцоолсон байна. | 1 | 43,478.4 | - | - | - | - | 1 | 43,478.4 | - | - | - | - |
| Булган аймаг дахь Автотээврийн үндэсний төв | 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад бараа материал, үндсэн хөрөнгийн хөдлөлийн тайлан тусгаагүй дутуу байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Булган аймаг дахь Автотээврийн үндэсний төв | 2022 оны А/40 тоот тушаалаар ээлжийн 3 харуулд илүү цагийн хөлс олгосныг etax.mta.mn цахим тайланд тайлагнахдаа гар олгосон дүнгээс тооцож татварыг дутуу тайлагнасан байна. | 1 | 1,173.00 | - | - | - | - | 1 | 1,173.0 | - | - | - | - |
| Говь-Алтай аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Тус байгууллага нь нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч дулааны тоолуур ашиглаагүй байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| Говь-Алтай аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Байгууллагын авто тээврийн хэрэгсэл нь тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугааргүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дорноговь аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Бүртгэлийн орлогыг тээврийн хэрэгслийн гэрчилгээ, маягт, үнэт цаастай, МЖЛ ХХК-ийн орлогыг дагалдах хуудастай, тээврийн хэрэгслийн үзлэгийн орлогыг үзлэгт орсон, тэнцээгүй тээврийн хэрэгслийн бүртгэлтэй тулгахгүйгээр борлуулалтын орлогыг тооцож байгаагаас зөвшөөрлийн орлогын бүртгэлд зөрүү үүсэхгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Дорноговь аймаг дахь Автотээврийн үндэсний төв | НБББББ-т заасны дагуу НДШ 1,353.9 мянган төгрөг, бичиг хэрэг, албан томилолтын зардлыг ерөнхий удирдлагын зардалд тусгаагүй, ББӨ-т тайлагнасан байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Дорнод аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цагалбарт хугацааг 13 хоногоор хоцроож, 2023 оны 02 дугаар сарын 28-ны 32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| Дорнод аймаг дахь Автотээврийн үндэсний төв | АйсВн ХХК-тай байгуулсан Зорчигч тээврийн үйлчилгээний хөлсийг хувийн харилцах данс руу шилжүүлсэн байна. | 1 | 473,376.1 | - | - | - | - | 1 | 473,376.1 | - | - | - | - |
| Дорнод аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Бараа материалын санхүүгийн тайланд тусгагдсан дүн тодруулга тайлангийн дүн хоорондоо зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. | 1 | 1,579.9 | - | - | - | - | 1 | 1,579.9 | - | - | - | - |



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛ ХЯЗГААРЛАЛТТА САНАЛ ДҮГНЭЛ

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дорнод аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Санхүүгийн тайланд тусгасан өглөгийн үлдэгдэл тооцоо нийлсэн актаас 923.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 1 | 923.0 | - | - | - | - | 1 | 923.0 | - | - | - | - |
| Дундговь аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Нэр бүхий нэг ажилтанд 138.0 мянган төгрөгийн цалинг дутуу бодож олгосон байна. | 1 | 138.0 | 1 | 138.0 | - | - | - | - | - | - | - | - |
| Дундговь аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Болзошгүй тохиолдлын зардлаас 715.0 мянган төгрөгийн биеийн тамирын хувцас худалдаж авсан байна. | 1 | 715.0 | - | - | 1 | 715.0 | - | - | - | - | - | - |
| Орхон аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Байгууллагын дотоод журамд шөнийн нэмэгдлийн хэрхэн тооцох талаар зохицуулалт тусгагдаагүй 1 сард шөнийн нэмэгдлийг тооцохдоо илүү цагийн тооцооллоор 1,316.0 мянган төгрөгийг олгосон байна. | 1 | 1,316.0 | - | - | - | - | 1 | 1,316.0 | - | - | - | - |
| Орхон аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Суудлын автомашины 100 км-т зарцуулах, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр шатахууныг тооцож 660.7 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 660.7 | - | - | - | - | 1 | 660.7 | - | - | - | - |
| Сүхбаатар аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг нягтлан бодогчоор баталгаажаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Сүхбаатар аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Албан ажлын автомашинуудад мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулаагүй нь Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дарга, Сангийн сайдын 2022 оны 95/260 дугаартай хамтарсан тушаалаар баталсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | | | | | | | | | | | | |
| Сүхбаатар аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Бэлтгэн нийлүүлэгч, харилцагч байгууллагатай тооцоо нийлж, авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Сэлэнгэ аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Иргэнд хандив олгосон байна. | 1 | 200.0 | - | - | 1 | 200.0 | - | - | - | - | - | - |
| Сэлэнгэ аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Төлбөрийн цахим баримтыг бөөн дүнгээр баталгаажуулсан байна. | 1 | 6,008.0 | - | - | - | - | 1 | 6,008.0 | - | - | - | - |
| Сэлэнгэ аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Санхүүгийн программын бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн тайлан, бараа материалын хураангуй тайлангийн дүн хоорондоо зөрүүтэй тайлагнагдсан байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Сэлэнгэ аймаг дахь Автотээврийн үндэсний төв | 2022 онд зохион байгуулалтын бүтцээр дотоод ажил, аж ахуй хариуцсан мэргэжилтэн шинээр бий болгон тус газрын даргаар ажиллаж байсан Ж.Батцогтыг томилон ажиллуулж, цалин олгосон байна. | 1 | 13,461.4 | - | - | - | - | 1 | 13,461.4 | - | - | - | - |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛ
01 ХЯЗГААРЛАГДМАЛ
САНАЛ ДҮГНЭЛ

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ховд аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Жаргалант сумын Рашаант багийн Мандах наран хороололд байрлалтай 56810.3 м2 хэмжээ бүхий 1,022,585.4 мянган төгрөгийн үнэлгээ бүхий автотээврийн вокзалын газрыг газрын мэдээллийн санд бүртгээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Ховд аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Тус төвийн бүртгэлтэй 56810.3 м2 хэмжээ бүхий газраас аймгийн ГХБХБГ-аас аж ахуйн нэгж иргэдэд 3000м2 хэмжээ бүхий газрын давхардуулан олгосон, тус газарт авто тээврийн хувийн үйлчилгээ үзүүлэх вокзал баригдаж эхлэсэн, тус байгууллага жил бүр газрын төлбөрийг бүрэн төлсөөр байгаа тул авто тээврийн үйл ажиллагаа хэрхэн явуулах нь маргаантай байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Хэнтий аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Тайлант онд ажилчдын хүүхдийн бэлэг худалдаж авахад 1,280.0 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан байна. | 1 | 1,280.0 | 1 | 1,280.0 | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | | **37** | **658,498.6** | **3** | **2,078.0** | **8** | **49,981.2** | **26** | **606,439.4** | **-** | **-** | **-** | **-** |

## Харьяа салбаруудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Салбарууд | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил* | | | | | | | | | |
| Автотээврийн төвийн Цогтцэций салбар | Шилэн дансны цахим хуудсанд 706,856.9 мянган төгрөгийн мэдээлэлд 43 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Баянхонгор аймаг дахь Автотээврийн Үндэсний төв | Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27,677.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Булган аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 251,712.9 мянган төгрөгийн 14 гүйлгээ, зарлагын 6,192.2 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна | 1 | 257,905.1 | - | - | 1 | 257,905.1 | - | - |
| Хэнтий аймаг дахь Автотээврийн үндэсний төв | Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 392.322.7 мянган төгрөгийн 15 гүйлгээ, зарлагын 38.205.4 мянган төгрөгийн 4 гүйлгээ, худалдан авалтын 121,267.2 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна. | 1 | 551,795.3 | - | - | 1 | 551,795.3 | - | - |
| **Дүн** | | **4** | **809,700.4** | - | - | **2** | **809,700.4** | **2** | - |



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛ
ХЯЗГААРЛАЛТТ
САНАЛ ДҮГНЭ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2023 оны 03 дугаар сарын 21 № 130/А0150055 Улаанбаатар хот

СНАГ-2023/139/НА-СТА-ТОА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий ажилтанд өвчтэй, чөлөөтэй үед ажилласнаар цагийг бүртгэж, 1,266,095.24 (нэг сая хоёр зуун жаран зургаан мянга ерэн тав) төгрөгийн цалин бодож олгосон, удирдах ажилтны зөвлөгөөнд зориулж 10,000,000.00 (арван сая) төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "*нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчим*", 18 дугаар зүйлийн 18.1 "*нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*", 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 "*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана*", 15.2.3 " *сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх*", гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий ажилтанд илүү олгосон цалин хөлс 1,266,095.24 (нэг сая хоёр зуун жаран зургаан мянга ерэн тав) төгрөг, удирдах ажилтны зөвлөгөөнд зориулж зарцуулсан 10,000,000.00 (арван сая) төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Автотээврийн үндсэний төвийн дарга /Б.Гүрсоронзон/, ерөнхий нягтлан бодогч Г.Дуламханд нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР — Ц.ХОСЖАРГАЛ

АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Л.МАЙЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 03 дугаар сарын 21. № 476/А0150055 Улаанбаатар хот

СНАГ-2023/39/НА-СТА-10А.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төвийн захирлын тушаалаар нэр бүхий 3 дэд захирлын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөр дуусгавар болгож, 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор ажил хүлээлцэх тухай шийдвэр гарсан боловч 6 дугаар сард 14 хоног ажиллаж, 5,071,500.00 (таван сая далан нэгэн мянга таван зуу) төгрөгийн цалинг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*", Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3 "*Ажил олгогч ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон тухай шийдвэртээ ажил хүлээлгэн өгөх хугацааг заана*", 83.5 "*Ажил олгогч ажилтанд энэ хуулийн 83.3-т заасан хугацааны цалин хөлсийг тооцож олгоно.*" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Захирлын тушаалыг мөрдөж ажиллагаагүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төвийн дарга /Б.Гүрсоронзон/, ерөнхий нягтлан бодогч /Г.Дуламханд/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250*

Z:\Alban Shaardlaga\20230315 SNAG-43.Docx

0001081016

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 03 дугаар сарын 21 № 477/А0150055 Улаанбаатар хот

СНАГ-2023/39/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, удирдах ажилтны хурал, зөвлөгөөн зохион байгуулж 40,984,000.00 (дөчин сая есөн зуун наян дөрвөн мянга) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2 "*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана*", 15.2.3 "*сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх*" Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын 5.1 "*бүх төрлийн сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах*", гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төвийн дарга /Б.Гүрсоронзон/, ерөнхий нягтлан бодогч Г.Дуламханд нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Albon Shaardlaga\2023\0315 SNAG-43.Docx

0001081018

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 03 дугаар сарын 21 № 479/А015005 Улаанбаатар хот

СНАГ-2023/39/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 35 байгууллага, иргэдээс худалдаж авсан 192,286,768.74 (нэг зуун ерэн хоёр сая хоёр зуун наян зургаан мянга долоон зуун жаран найм) төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн цахим и баримтыг бүрдүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төвийн дарга /Б.Гүрсоронзон/, ерөнхий нягтлан бодогч Г.Дуламханд нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ

АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Albon Shaardlaga\20230315 SNAG-43.Docx

0001081019

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 03 дугаар сарын 21 № 480/А0150055 Улаанбаатар хот

СНАГ-2023/39/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

CITA олон улсын гишүүнчлэлийн төлбөрийг шилжүүлэхдээ 1,601,609.10 (нэг сая зургаан зуун нэг мянга зургаан зуун ес) төгрөгийн НӨАТ, ААНОАТ-ыг ногдуулж, төсөвт төлөөгүй байна.

Энэ нь Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6.8 *".....Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн энэ хуулийн 4.1.6, 4.1.7, 8.3-т заасан орлого"*, 20.2.4 *"энэ хуулийн 18.6.6, 18.6.8-д заасан орлогод 20 хувиар"*, НӨАТ-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 *"оршин суугч бус этгээдээс энэ хуулийн 7.2.5-д гаалийн бүрдүүлэлт хийлгээгүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа үнийн дүнгээс албан татварыг суутган авч төсөвт төлнө"* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Олон улсын гишүүнчлэлийн төлбөрөөс НӨАТ, ААНОАТ-ыг нөхөн ногдуулаагүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төвийн дарга /Б.Гүрсоронзон/, ерөнхий нягтлан бодогч Г.Дуламханд нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2023\0315 SNAG-43.Docx

0001081021

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 481/А0150055 Улаанбаатар хот

СНАГ-2023/39/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд чөлөөлөгдөх орлогын дүнг 156,952,867.22 төгрөгөөр илүү тайлагнасан, Дотоодын зах зээлээс худалдан авсан 4 ширхэг суудлын авто машины 47,752,197.00 төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг хасаж тооцсон, Нэр бүхий 4 байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлсөн 77,276,102.91 төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг хуульд заасны дагуу хувь тэнцүүлж хасалт хийгээгүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "*Дараах үйлчилгээг албан татвараас чөлөөлнө*", 13.5.13 "*Автотээврийн тухай хуулийн 3.1.11-д заасан нийтийн тээврийн үйлчилгээ*", 14 дүгээр зүйлийн 14.6.1 "*суудлын машин, түүний эд анги, сэлбэг" албан татварын дүнгээс хасахгүй*", 14.1.4.а "*барилга, байгууламж 10 жилээр*", *14.1.5.б "тоног төхөөрөмж 5 жилээр" тус тус хувь тэнцүүлэн хасагдуулна*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах*" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй нийт 281,981,167.13 (хоёр зуун наян нэг сая есөн зуун наян нэг мянга нэг зуун жаран долоо) төгрөгийн зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төвийн дарга /Б.Гүрсоронзон/, ерөнхий нягтлан бодогч Г.Дуламханд нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ц.ХОСЖАРГАЛ |
| АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Л.МАЙЦЭЦЭГ |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 03 дугаар сарын 21 № 474/A0150055 Улаанбаатар хот
СНАГ-2023/39/НА-СТА-ТӨА

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа татварын тодорхойлолтод өрийн үлдэгдэлтэй, санхүүгийн чадавхын шалгуурыг хангаагүй, үнэлгээний хорооны даргын шийдвэргүйгээр нэр бүхий 4 байгууллагатай гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 "*Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй*", 15 дугаар зүйлийн 15.1 "*Захиалагч тендерт оролцогчоос гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхитайгаа баталсан нотолгоо ирүүлэхийг шаардаж болно*", 15.2 "*Захиалагч санхүүгийн чадавхын шаардлагыг тендерийн, эсхүл урьдчилсан сонголтын баримт бичигт тусгана* " гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллагаагүй буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Автотээврийн үндэсний төвийн дарга /Б.Гүрсоронзонд/ даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — Ц.ХОСЖАРГАЛ
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Л.МАЙЦЭЦЭГ

ATA9693 9006109 9023030583

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 03 дугаар сарын 21 № 475/A015 0055 Улаанбаатар хот

СНАГ-2023/39/НА-СТА-ТӨА

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Татварын etax програмын тооцооллоор Суутган татвар 22,000,000.00 төгрөг, НӨАТ-ын өглөг 1,297,409.80 төгрөг, ААНОАТ 6,169,413.80 төгрөгийн тус тус авлагатай, тэмдэгтийн хураамжийн тайлан 21,092,100.00 төгрөгийн өглөгтэй байхад тус төвийн тайланд тусгаагүй, татварын тооцооллыг эцэслээгүй санхүүгийн тайлан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19."*суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг*", 25 дугаар зүйлийн 25.6 "*Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ*" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Автотээврийн үндэсний төвийн дарга /Б.Гүрсоронзонд/ даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ

АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

ATA9693 9006109
9023030583

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250*

Z:\Alban Shaardlaga\20230315 SNAG-43.Docx

0001081027

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 03 дугаар сарын 21 № 469/АО150055 Улаанбаатар хот

СНАГ-2023/39/НА-СТА-ТӨА

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын харьяа 28 салбарын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах тухай Үндэсний аудитын газрын 2022 оны 455/АО160067 дугаар сахилгын хариуцлага тооцох албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11.*"нэгтгэсэн санхүүгийн тайлан" гэж Компанийн тухай хуулийн 6.4-т заасан санхүүгийн тайланг"*, 4.1 *"Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө"*, Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 *" Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ"*, 6.2 *" Хараат компани бие даасан тайлан баланс гаргадаг хуулийн этгээд байна"* гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 *"Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ"* гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Автотээврийн үндэсний төвийн дарга /Б.Гүрсоронзонд/ даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ц.ХОСЖАРГАЛ |
| АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Л.МАЙЦЭЦЭГ |

АТА9693 9006109
9023030583

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Albon Shaardlaga\2023\0315 SNAG-43.Docx

0001081029